



## БОДЛОГЫН ТОЙМ: ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮС

2004 îî ù 4 äçãýýä ãàäüí 12

### Оршил

Үйлдвэр, Худалдааны Яам (ҮХЯ)-ны хүсэлтээр ЭЗБШӨЧ Төсөл дараахь чиглэлээр үнэлгээ хийсэн болно.

Монгол Улсын Худалдааны чөлөөт бүс (ХЧБ)-ийн хөтөлбөрийн эрх зүйн орчинг олон улсын өнөөгийн шилдэг туршлага, сургамжуудтай харьцуулах;  
Монгол Улсад ХЧБ байгуулж буй үйл явцыг өнөөгийн шилдэг туршлагаудтай харьцуулах;  
Алтанбулаг, Зам-Үүдэд Худалдааны чөлөөт бүс (ХЧБ)-ийг байгуулах төслийн хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх;

### Дүгнэлт

1. Монгол Улсын ХЧБ-ийн хөтөлбөрийг олон улсын өнөөгийн шилдэг туршлагатай харьцуулан үнэлэхэд эрх зүйн орчин болон ХЧБ-ийг байгуулах үйл явцад учир дутагдалтай зүйлс буй нь ажиглагдсан.
2. ХЧБ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам боловсруулж үйл ажиллагааны стандарт журам (ҮАСЖ)-д тусгаагүй явдал нь олон улсын шилдэг туршлагад нийцүүлэхэд шаардагдах ил тод, урьдчилан таамаглах бололцоотой байдлын наад захын түвшинг хангахад саад болж байна.
3. Үр ашгийн шинжилгээ зэрэг зайлшгүй хийх шаардлагатай ажлуудыг Замын-Үүдийн худалдааны чөлөөт бүсийг байгуулах ажилд орхигдуулсан байна.
4. Замын-Үүд, Алтанбулагийн ХЧБ-үүдийн дэд бүтцийн хэрэгцээг хангахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн асуудал тодорхойгүй байна.
5. Худалдааны чөлөөт бүсийг байгуулах явцад олон улсын шилдэг туршлагаас гажих нь өнгөрсөн хугацаанд бусад орнуудад гарч байсан алдаануудыг давтах эрсдэлд оруулан Монгол Улсын Засгийн газар урьдчилан харах боломжгүй буюу нийгмийн нэн тэргүүний бусад хэрэгцээг нөхөх аргагүй байдалд оруулах "далд зардал" буюу татаасыг гаргахад хүргэж болох юм.

### Зөвлөмж

1. Монгол Улсын засгийн газар нэгэнт хэрэгжүүлж эхэлсэн ХЧБ-ийн төслүүдийн эдийн засгийн үр ашгийн шинжилгээг олон улсын өнөөгийн шилдэг туршлагауд дээр тулгуурлан хийх хэрэгтэй.
2. Монгол Улсын Засгийн газар олон улсын шилдэг туршлагыг дагаж мөрдөх асуудлыг анхааралдаа авч Замын-Үүдэд худалдааны чөлөөт бүсийн худалдааны бүс байгуулах боломжтой эсэхийг иж бүрэн судлах хэрэгтэй.
3. Монгол Улсын Засгийн газар олон улсын шилдэг туршлагаудад тулгуурлан ХЧБ-ийн хөтөлбөрийнхөө эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгтэй.
4. Монгол Улсын Засгийн газар Хятад Улсын Эрээн хоттой хөрш зэргэлдээ орших байрлалтай холбогдон бий болсон зах зээлийн боломж, хөрөнгө оруулагчдын сонирхолд тулгуурлан Замын-Үүдэд амралт, зугаа цэнгээний үйл ажиллагаа явуулах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй.
5. Монгол Улсын Засгийн газар тус улсад үр ашигтай болохыг олон улсын туршлагад тулгуурлан тооцож гаргах шаардлагатай ажлуудыг дуусгахаас өмнө Замын-Үүдийн худалдааны чөлөөт бүс байгуулах тендер зарлах асуудлыг хойшлуулах нь зүйтэй.

### Мэдээллийн эх сурвалж

ЭЗБШӨЧТ-ийн техникийн үндэслэлийн тайлан буюу □Монгол Улсын Худалдааны чөлөөт бүс хөтөлбөрийн үнэлгээ, бүсийн байдалтай танилцсан дүн шинжилгээ□-г харна уу. Монгол Улс, Улаанбаатар хот, ЭЗБШӨЧТ, 2004 оны 3 дугаар сар.